



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/44

Хэрлэн сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт, лабораторийн шинжилгээ,
шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-9.9, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, лабораторийн шинжилгээ, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 01-нийг хүртлэх хугацаанд чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, шаардлагатай вакцин, био бэлдмэл, эмийн бодис, урвалж, хамгаалах хувцас хэрэгслэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ